<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,045.70</b>	<b>21,509.78</b>	<b>2,535.92</b>	<b>89.45</b>

330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,045.70	21,509.78	2,535.92	89.45
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>178,588.90</b>	<b>24,611.82</b>	<b>153,977.09</b>	<b>13.78</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,800.00	24,131.82	27,668.19	46.59
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	480.00	520.00	48.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	125,788.90			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	126,066.01	-126,066.01	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	173,334.70	-173,334.70	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>110,855.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>110,855.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>84,542.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,307.50</b>
210101	Үндсэн цалин	2,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,307.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,232.00</b>
210402	Тээвэр, шатахуун	611.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,825.43</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,861.00
210502	Хоол, хүнс	1,964.43
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,679.99</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	999.99
210604	Урсгал засвар	2,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>102.80</b>
210702	Дотоод албан томилолт	102.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,198.25</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,198.25
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,196.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,196.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,313.19</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,313.19</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,313.19
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>110,855.66</b>

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,855.66</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,701.66

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч И.Батсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, төлөвлөлт болон хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж гүйцэтгэв.

Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймгийн Төрийн аудитын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 3/460 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Эрдэнэ сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, цомхон чадварлаг боловсон хүчинтэйгээр төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангаж ажиллаж, салбар салбартаа үйл ажиллагаагаар тэргүүлэн ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх замаар бизнест шаардлагатай хатуу дэд бүтцийг хөгжүүлж, эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, бизнесийн хөгжлийг дэмжинэ.
- Эдийн засгийн салбаруудын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэн дэмжиж хүн амын эрэлт, хэрэгцээг бүрэн дүүрэн хангана.
- Төр, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хүмүүнлэг, эрүүл, боловсролтой иргэдийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчноо хамгаалж, нөөц баялгийг зүй зохистой ашиглан байгалийн тэнцвэрийг хадгална.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Эрдэнэ сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд сумын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгө сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 3,497.8 сая төгрөгийн 1 хувь буюу 35.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 5,297.3 сая төгрөгийн 1 хувь 53.0 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 134.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 211.4 сая төгрөг болж, 76.6 сая төгрөгөөр өссөн.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Касст байгаа бэлэн мөнгө</b>				
Банканд байгаа бэлэн мөнгө	134.8	211.4	76.6	56.8
<b>Замд яваа мөнгөн хөрөнгө</b>				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>134,8</b>	<b>211,4</b>	<b>76,6</b>	<b>56,8</b>

*Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 211.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 121.8 сая, эцсийн үлдэгдэл 145.8 сая төгрөг болж, 24 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №..... Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	3.0	17.9	14.9
Бусад авлага	0.2	25.8	25.6
Зээлийн авлага	118.5	102.2	-16.3
<b>Дүн</b>	<b>121,8</b>	<b>145,8</b>	<b>24,0</b>

*Эх сурвалж: Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 102.2 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээл олголтоос үүссэн /хугацаа хэтэрсэн, шүүхэд шилжүүлсэн, эвлэрлийн гэрээ байгуулсан/ 120,0 сая төгрөгийн авлага.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 49.2 сая, эцсийн үлдэгдэл 0 сая төгрөг болж, 49.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №... Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	49,2	0	-49,2
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>49,2</b>	<b>0</b>	<b>-49,2</b>

*Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 49,2 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- 2019 онд Ерөнхий боловсролын сургуулийн дотор халаалтын системийн урсгал засварын ажил дуусаж капиталжуулснаас шалтгаалж буурсан байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 315.7 сая, эцсийн үлдэгдэл 395.6 сая төгрөг болж, 79.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	88,5	95,9	7,4
Эм боох материал	14,5	28,7	14,2
Бичиг хэргийн материал	10,3	11,6	1,3
Аж ахуйн материал	20,9	22,5	1,6
Сэлбэг хэрэгсэл	3,4	7,3	3,9
Түлш шатах тослох материал	3,2	7,4	4,2
Барилгын засварын материал	2,6	6,2	3,6
Хүнсний материал	6,3	4,9	-1,4
Бусад хангамжийн материал	163,3	208,2	44,9
Мат амьтан	2,7	2,9	0,2
<b>Дүн</b>	<b>315.7</b>	<b>395.6</b>	<b>79.9</b>

*Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч нөөцөлсөн, мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал бүртгэгдээгүй байна. Үлдэгдэл нэмэгдсэн шалгаан нь ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй материалыг данс бүртгэлд авснаас шалтгаалжээ.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,858.9 сая, эцсийн үлдэгдэл 5,695.7 сая төгрөг болж 1,836.8 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1505,9	2946,8	1440,9
Тээврийн хэрэгсэл	293,1	343,9	50,8
Машин тоног төхөөрөмж	446,3	533,9	87,6
Тавилга эд хогшил	189,3	209,1	19,8
Түүх соёлын дурсгалт зүйл	0,1	0,9	0,8
Дуусаагүй барилга байгууламж	88,5	0	-88,5
Номын фонд	16,5	16,6	0,1
Бусад үндсэн хөрөнгө	1178,8	1496,9	318,1
Програм хангамж	116,8	123,1	6,3
Бусад биет бус хөрөнгө	23,6	24,4	0,8
<b>Дүн</b>	<b>3,858.9</b>	<b>5,695.6</b>	<b>1,836.7</b>

Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 63.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,911.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, 49.6 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө акталж хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 2019 оны 88.5 сая төгрөгийн хүлээн аваагүй барилга байсныг 2020 онд хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон. Одоо 118.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8.3 сая, эцсийн үлдэгдэл 2.4 сая төгрөг болж, 5.9 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>				
Байгууллагад төлөх өглөг	8.3	2.4	-5.9	-71
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>				
<b>Нийт дүн</b>	<b>8.3</b>	<b>2.4</b>	<b>-5.9</b>	<b>-71</b>

Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2.4 сая төгрөг нь орон нутгийн нэмэлт дансны үлдэгдэл байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,489.5 сая, эцсийн үлдэгдэл 5,278.3 сая төгрөг болж, 1,788.8 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,779.1	1,779.1	0	0
Хуримтлагдсан үр дүн	1,445.9	3,234.7	1,788.8	123.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264.5	264.5	0	0
<b>Дүн</b>	<b>3,489.5</b>	<b>5,278.3</b>	<b>1,788.8</b>	<b>123.7</b>

Эх сурвалж Эрдэнэ сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,278.3 сая төгрөг болж, 1,788.8 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Тайлант онд нийт 109.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнд, татварын орлого 90.2 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 19.3 сая төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Татварын 7 төрлийн орлогыг бүрдүүлж ажилласан байна. Бусад татварын бус орлогоос 19.3 сая төгрөг, үнэ төлбөргүй 1,861.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 71.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод тусгасан байна.

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 1,163.4 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлгээр 251.9 сая төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгт 520.3 сая төгрөг, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардалд 200.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагын урсгал зардалд 21.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 117.9 сая төгрөг, нийт 2,275.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд нийт 2,528.4 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд, үйл ажиллагааны зардлын дүн 2,523.5 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 4.9 сая төгрөг байна. Нийт зардалд материаллаг хэмжээний цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал /54.4 хувь/, байр ашиглалттай холбоотой зардал /10.6 хувь/, хангамж, бараа материалтай холбоотой зардал /16.7 хувь/, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал /9.1 хувь/ байна.

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 02/04 дугаар тогтоолд тайлант онд 70.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 90.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 128.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлогын албан татвар	5.7	2.4	-3.2	41.96

Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	28.0	50.9	22.9	179.1
Хадгаламжийн хүүгийн орлого	19.9	17.7	-2.2	89.1
Бууны албан татвар	2.2	2.2	0	100
Хөрөнгө борлуулсны орлого	0.05	1.3	1.2	2596
Улсын тэмдэгтийн хураамж	7.8	1.5	-6.3	18.96
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.05	0	-0.05	0
Ан агнуурын нөөц ашигласны төлбөр		10.0	10.0	0
Хог хаягдлын хураамж	6.7	4.2	-2.5	62.74
<b>Нийт дүн</b>	<b>70.4</b>	<b>90.2</b>	<b>19.8</b>	<b>128.1</b>

Орон нутгийн орлого 19.0 сая төгрөгөөр давсан нь ан агнуурын нөөц ашигласны төлбөр орсон байхад тодотголоор хассан мөн хувь хүнээс суутгасан орлогын албан татвар нь хилийн 0129 анги мах их хэмжээгээр бэлдсэн нь шалтгаалсан байна.

### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,271.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,271.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс орлогыг 2,271.4 сая төгрөгөөр, зардлыг 2,271.4 сая төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,478.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,204.6 сая төгрөгийг урсгал зардалд, 274.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,430.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 845.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 178.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,415.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 721.8 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 21.5 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 24.6, нийт 2,183.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 27.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, 270.6 сая төгрөгийн санхүүжилтийг улс болон орон нутгийн төсвөөс дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 24.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 154.0 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн тусгай сангийн дансны эхний үлдэгдлийг орлогод төлөвлөсөн нь шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,180.7 сая төгрөг буюу 88.0 хувьтай /298.1 сая төгрөгийн хэмнэлттэй/ байгаа нь, сум хөгжүүлэх сангаас 122.0 сая төгрөг зарцуулаагүй, ОНХС-ийн хөрөнгийг 46.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, байгаль хамгаалах нөхөн сэргээлийн сангийн 32.5 сая төгрөг, зарим байгууллагын урсгал зардлын төсөв 27.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн, бусад төсвийн байгууллага 69.9 сая төгрөг зарцуулаагүй хэмнэсэн шалтгаалсан байна. Нийт зардал 88.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах зардлууд хэмнэгдсэн болон дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон НДШ-ийн зардал 43.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь /соёл-0,8, ЗДТГ-34.7, сургууль- 4.4, Цэцэрлэг 3.4/
- Норматив зардал 25.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь хоол, хүнсний зардал сургууль, цэцэрлэг дээр хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.
- Бараа үйлчилгээний бусад зардал 126.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь СХС-ийн сангаас 122.0 сая төгрөгийн зээл олгоогүй, бусад байгууллагын үйл ажиллагаанаас 4.1 сая төгрөгийн зардал гаргаагүйтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 26.7 сая төгрөгийг улсын төсөв, 1.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээнд 251.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 228.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 31.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 79.7 сая төгрөг, нийт 110.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс өвс тэжээл худалдан авахад 8.2 сая төгрөг, мал тооллогын ажил 4.9 сая төгрөг, урамшуулалд 4.7 сая төгрөг, халдвар хамгаалал сахиулах үйл ажиллагаанд 21.4 сая төгрөг, хөдөө аж ахуйн чиглэлээр 21.0 сая төгрөг, бусад үйл ажиллагаанд нийт 24.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 26.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 158 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							

Албан шаардлага						
Зөвлөмж	1	0	1	0		100
Нийт						

Өмнөх аудитаар Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүү, бүртгэлийг программ хангамжаар гүйцэтгүүлэх талаар 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг сумын Засаг даргын 2020 оны 3/496 дугаар албан бичгээр манай байгууллагад ирүүлсэн байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3 дүгнэлт өгсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 алдаа, зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 113.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 106.4 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 7.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 4.1 Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Эрдэнэ сумын ИТХ-ын 2012 оны 3 дугаар тогтоолоор гэрийн тэжээвэр нохой, муураас авах хураамжийн хэмжээг тогтоосон байгаа боловч орлогын төлөвлөгөөнд тусгаагүй, хэрэгжүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл: Орлогын боломжит эх үүсвэрийг орхигдуулах, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхгүй байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлж, орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хариу тайлбар ирүүлээгүй болно.

### 3.2 Орлогын холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Сумын орлогыг төлөвлөхдөө тооцоо, судалгаанд үндэслээгүй, орлогыг бүрдүүлэх эх үүсвэрийн талаар тоо, мэдээлэл байхгүй, мөн гүйцэтгэлд тааруулан орлогыг тодотгодог байна.

4.2.2 Эрсдэл: Орлогын төлөвлөгөөтэй уялдуулан зардлыг үндэслэлгүйгээр төлөвлөх, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Сумын орлогыг бүрдүүлэг иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг бэлтгэж, орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэж боловсруулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:Хариу тайлбар ирүүлээгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

дга-2021/4/ста-ттз

Эрдэнэ сумын Засаг дарга

Огноо:

Аудитын нэр:

Аудитын код:

2021 Шалгарсан байгууллагын нэр	Аудитын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал	Овог нэр
		1	2	3	4	5
1	ЗДТГ	Тайлант онд нийт 7,125.6 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. Энэ нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 670,7 мянган төгрөгийн цалин олгосон, түлш халаалтын зардлаас 5,000.0 мянган төгрөгийг засварын ажлын хөлс төлөхөд, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,244.9 мянган төгрөгийн эд худалдан авахад, даатгалын үйлчилгээний төлбөрийн зардлаас 210.0 мянган төгрөгөөр нотариатын дардасны үнийг шилжүүлэн зарцуулсан байна.	7.1	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал. Ч.Өлзиймөнгө
2	ЗДТГ	Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүртгэлийг үзэхэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд ашиглаж байна.	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал. Ч.Өлзиймөнгө
3	ЗДТГ	Тайлант онд хагас жилийн болон жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийх тухай тушаал байхгүй байна. Мөн тооллогын баримт гэсэн нэртэй архивын баримтыг үзэхэд тооллого хийсэн гэх баримт материал хангалтгүй, тооллогын комиссын илтгэх хуудас байхгүй байна. Энэ нь 2020 онд тус байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд тооллого хийсэн эсэхийг бүрэн нотлох боломжгүй байна.	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал. Ч.Өлзиймөнгө
4	ЗДТГ	Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 480.0 мянган төгрөгийн төвлөрүүлж, 520.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Төлөвлөсөн орлого 52 хувиар тасарсан байна.	0.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал. Ч.Өлзиймөнгө
5	ЗДТГ	Тайлант оны цалингийн бүртгэлийг үзэхэд урьдчилгаа цалинг авлагаар бүртгэх байтал өглөгөөр бүртгэж нийт 8,820.0 мянган төгрөгийг буруу бүртгэж тайлагнасан байна. Үүнийг аудитын явцад залруулав. Мөн тайлант онд олгосон урамшууллыг үзэхэд улиралд олгосон урамшууллын хэмжээ тогтоосон дүнг баримтлан олгосон байна.	8.8	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал. Ч.Өлзиймөнгө

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ЗДТГ	Төлөвлөлтийн үе шатны ирүүлсэн эхний хагас жилийн тайлангийн орлого үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардалд 2,467.8 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Энэ нь тус байгууллагын хагас санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн нь жилийн эцсийн тайланд засагдсан байна.	2.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Алтанцацрал, Ч.Өлзиймөнгө
7	ЭМТ	Иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авалт хийхдээ НӨАТ баримт аваагүй	2.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Цэцэгсүрэн, Т.Амгалан
8	Сургууль	Төсвийн хэмнэлтээс татварт илүү шилжүүлсэн	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Баттуяа, Э.Эрдэнэсүвд
9	Цэцэрлэг	Татварын тооцоо нийлсэн актаар суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар илүү төлөлттэй.	0.3	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Уранбилэг, Э.Эрдэнэсүвд
10	СХС	Өмнөх онд зээлийн хүүгийн авлагын тооцооллыг дутуу тайлагнасан байна.	3.8	Залруулсан	Засаг дарга, Санхүү албаны дарга	И.Батсүрэн, Ч.Өлзиймөнгө
11	ОНХС	Дуусаагүй барилгыг тайлант оны үр дүнд илэрхийлээгүй өмнөх үеийн үр дүн рүү хаасан байна.	88.5	Залруулсан	Засаг дарга, Санхүү албаны дарга	И.Батсүрэн, Ч.Өлзиймөнгө
12	Засаг дарга	ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлж, орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилж ажиллах.	0.0	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга	И.Батсүрэн, Ч.Өлзиймөнгө
13	Засаг дарга	Сумын орлогыг бүрдүүлэг иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг бэлтгэж, орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэж боловсруулах.	0.0	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга	И.Батсүрэн, Ч.Өлзиймөнгө
<b>ДҮН</b>			<b>113.5</b>			